

## "МОНГОЛ ОРНЫ ХӨГЖИЛД" VIII ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛОВ

Written by stockholm

Tuesday, 08 May 2012 12:35 - Last Updated Tuesday, 08 May 2012 13:01

---



Британийн Монголчуудын Холбоо ИБУИНВУ дахь Монгол Улсын Элчин сайдын яам хамтран гадаадад суралцагч Монгол залуусынхаа мэдлэг оюуныг эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах нэгэн ундарга болгох зорилгоор "Монгол орны хөгжилд" чуулга уулзалтыг 2005 оноос хойш жил бүр уламжлал болгон зохиож ирсэн билээ.

Энэ жилийн VIII чуулга уулзалтыг "Ондор технологи-Европын стандартыг нэвтрүүлэх боломж" сэдвийн дор Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хороо, Монгол Улсаас ИБУИНВУ-д болон Шведийн Вант Улсад суугаа Элчин сайдын яамдууд, Европ- Монголын нийгэмлэг, Британийн Монголчуудын Холбоо, Швед дэх Монголчуудын Үндэсний Холбоо, Цахим Ортоо Холбоо зэрэг байгууллагууд хамтран онгорсон амралтын өдрүүдэд нийгмийн хөгжлийн хосгвй влгэр жишээ Умардын загварын олгий болсон Швед улсын нийслэл, Скандинавын Хойгийн тов, эртний тvvхт Стокгольм хотноо зохион байгуулав.

Чуулга уулзалтад Монгол Улсаас Шведийн Вант улсад суугаа Онц богоод бүрэн эрхт

## "МОНГОЛ ОРНЫ ХӨГЖИЛД" VIII ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛОВ

Written by stockholm

Tuesday, 08 May 2012 12:35 - Last Updated Tuesday, 08 May 2012 13:01

---

Элчин сайд Б.Энхмандах, Монгол Улсаас ИБУИНВУ-д суугаа Онц богоод бүрэн эрхт Элчин сайд Б.Алтангэрэл, ҮХШХ-ны Шинэтгэлийн бодлогын газрын дарга Б.Ганбат, МУИС-ийн дэд захирал Др.Ч.Ганзориг нарын албаны хүмүүс оролцож мэдээлэл хийж, Ирланд, Их Британи, Нидерланд, ХБНГУ, Унгар зэрэг улсад сурч, эрдмийн зэрэг цол хамгаалж буй монгол оюутан залуус, эрдэмтэд, судлаачид Монгол Улсад ондор технологи, био болон нано технологи, шинжлэх ухаан, технологийн дэд бүтцийг хөгжүүлэх асуудлуудаар 20 гаруй илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Чуулга уулзалтад хамрагдагчдын тоо жилээс жилд оргожин тэлж тэр хэмжээгээр утга агуулга, зорилго чиглэл нь баяжин арвижиж байгаа нь ажиглагдлаа. Энэ жилээс Монголын анд ноход, гадаадын, тэр дундаа ондор технологийн хөгжлийн тэргүүн шугаманд яваа АНУ, Финландын зарим эрдэмтэн судлаачид хүсэл сонирхлоороо чуулганд оролцож илтгэл санал тавьсан нь чуулганы нэг онцлог байв.



"Монгол орны хөгжилд" чуулга уулзалт болон Цахим Ортоо Холбоог санаачлагчдын нэг Британийн Монголчуудын Холбооны Тэргүүн Б.Цэрэнбатын идэвхи зүтгэлийг үнэлж, Монгол Улсын Ерөнхийлогч Ц.Элбэгдоржийн зарлигаар торийн дээд шагнал-"Алтан гадас" одонгоор шагнасныг Элчин сайд Б.Алтангэрэл, Б.Энхмандах нар гардуулсан нь эх орноосоо алс суугаа залуучуудын урам зоригийг бадраасан чухал үйл явдал болов.

Монгол улсын Ерөнхий сайд С.Батболд Чуулга уулзалтад оролцогсдод мэндчилгээ ирүүлж, "... судалгаанаас үзэхэд 2011 онд хилийн чанадад нарийн мэргэжил эзэмшин эх орондоо эргэн ирж ажиллаж буй иргэдээс 578 иргэн торийн болон Засгийн газрын

томоохон тосол хотолборвудийн хэрэгжилтэд гар бие оролцож, их бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж байгааг" дурьдаад Чуулга уулзалтын ажиллагаанд амжилт хвссэн байна.

Чуулга уулзалт анх удаа Лондонгоос оор газарт болсон нь уулзалтын бас нэг онцлог байв. Энэ нь олон тооны Монголчууд Швед Улсад ажиллаж амьдарч байгаатай, Монгол-Швед улсын харилцааны түүхэн болон оноогийн байдалтай тодийгвй Швед Улс бол дан ганц газрын баялагаар бус харин ондор технологи, шинэтгэлийн зохистой бодлого, хүмүүсийнхээ оюуны ондор чадавхиар хөгжлийнхоо хурдац, эдийн засгийн осолтийг хангаж чадаж буй Умардын орнуудын нэг гэдэгтэй холбоотой байлаа.

Чуулганд оролцогчид Шинжлэх ухааны Шиста хотхон /Kista Science City/-ы вйл ажиллагаатай танилцав. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар голлосон аж ахуй нэгж, судлаачид болон оюутнуудыг нэгтгэсэн шинэ санаачлагын уурхай гэж хэлж болох Стокгольм хот дахь ондор технологийн парк - Kista Science City нь МХХТ-ийн салбарт шинэ технологи, судалгаа, туршилт болон бизнесийн бололцоог бүрдүүлсэн нягтаршилтай газар богоод энд дэлхийд нолоо бүхий компаниуд, тухайлбал, Ericcson, Microsoft, IBM-аас гадна энд 1100 гаруй жижиг, дунд аж ахуйн нэгж вйл ажиллагаагаа явуулж байгаагийн 90 гаруй хувь нь экспортлогч компаниуд байдаг байна. Мон ирээдвйн МХХТ-ийн мэргэжилтнүүд болох Стокгольмын Их Сургууль, Хааны Технологийн Дээд сургуулийн 6800 оюутан энд суралцаж, 1100 гаруй эрдэмтэн судлаачид ажилладаг ажээ.

Энэ удаагийн чуулган омохийн адил хилийн чанад дахь Монголчуудын оюуны боломж бололцоог улс орны хөгжилд үр огоожтэйгоор ашиглах тогтолцоог бүрдүүлэх, ондор хөгжилтэй оронд суралцаж мэрэгшсэн боловсон хүчний эрэлт хэрэгцээг хангах зэрэг зорилгод чиглэсэн богоод Европын ондор хөгжилтэй орнуудад суралцаж буй залууст нэг дор цуглан сурч мэдснээ харилцан ярилцахын зэрэгцээ ажил хэргийн, анд нохдийн хэлхээ холбоо үүсгэх оргон боломжийг олгосноороо ч ач холбогдолтой боллоо.

Чуулга уулзалтыг зохион байгуулахад Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Хилийн Чанадад суугаа Монгол Улсын Иргэдтэй Хамтран Ажиллах Зөвлөл, ГХЯ, Монголын Эдийн засгийн Чуулган зэрэг тор, олон нийтийн байгууллага болон МАН, ИЗНН, МҮАН зэрэг улс торийн зарим нам тодийгвй "Newcom", "Ард капитал" групп, Monchemo ХХК, GeReGe Partners, Ten D Sec LLC зэрэг хувийн хэвшлийнхэн, Монгол Улсын Их Сургууль, Анагаах Ухааны Их Сургууль зэрэг боловсролын байгууллагууд ивээн тэтгэж, хандив тусламж үзүүлсэн байна.

Чуулга уулзалтын вээр "Европ-Монгол нийгэмлэг"-ийн гишүүдийн зөвлөлдөх хуралдаан болж, Европын орнуудад байгаа Монголын холбоодууд илүү нягтран ажиллах болон цаашдаа хийх вйл ажиллагааны талаар ярилцсан байна.

Дараагийн чуулга уулзалтыг 2013 онд Лондон хотноо зохион байгуулахаар тогтов.

Стокгольм, ЭСЯ, 2012 оны 5 дугаар сарын 7

# "МОНГОЛ ОРНЫ ХӨГЖИЛД" VIII ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛОВ

Written by stockholm

Tuesday, 08 May 2012 12:35 - Last Updated Tuesday, 08 May 2012 13:01

---